



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 5д

Номгон

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах  
иргэдийн тоо, шаардагдах зардлыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн алба дүйцүүлэн хаах журам”-ын 6 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлийн “а”, “б”, Засгийн газрын 2017 оны 51 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх албыг 2017-2019 онд хаах иргэдийн тоог нөөцтэй байлгах, аймгийн бүтээн байгуулалтад оролцуулах зорилгоор орон нутагтаа зохицуулалт хийж дүйцүүлэх албыг хаах иргэдийн тоог 60 болгож нэгдүгээр, шаардагдах зардлыг нэмэгдүүлж хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ыг удирдлага болгон дүйцүүлэх албыг хаалгах ажлыг зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг зохих журмын дагуу алба хаалгах, цаашид сумдаас дүйцүүлэн хаах иргэдийн тоог жигд байлгах, нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж, холбогдох газарт санал тавьж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хурандаа Б.Энхбаатар/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



116779